



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/98/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2022 оны 02 дугаар сар

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: myangnbuum@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа
Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
ОБЕГ	Онцгой байдлын Ерөнхий газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.08 № 213

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ОНЦГОЙ Т
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА
Ж.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	935,220,280.34	1,086,268,481.73
33	АВЛАГА	73,182,100.00	30,000,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	43,182,100.00	00.00
335	Бусад авлага	30,000,000.00	30,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	30,000,000.00	30,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	862,038,180.34	1,056,268,481.73
351	Түүхий эд материал	4,717,827.27	4,385,012.27
35110	Тусгай зориулалттай материал	2,738,352.27	3,002,652.27
35130	Эм боох материал	1,979,475.00	1,382,360.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	152,892,350.00	283,956,010.00
354	Хангамжийн материал	593,143,457.07	586,296,976.46
35410	Бичиг хэргийн материал	1,649,100.00	3,543,600.00
35420	Аж ахуйн материал	34,337,890.88	34,606,010.88
35430	Сэлбэг хэрэгсэл	9,769,025.00	3,037,000.00
35440	Түлш, шатах тослох материал	20,753,145.50	5,026,524.00
35460	Хүнсний материал	2,035,839.00	921,239.00
35470	Бусад хангамжийн материал	524,598,456.69	539,162,602.58
35500	Биологийн хөрөнгө	110,184,546.00	179,530,483.00
35600	Мал амьтад	1,100,000.00	2,100,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,452,088,570.06	4,122,779,764.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,452,088,570.06	4,122,779,764.24
392	Биет хөрөнгө	2,932,316,970.06	3,484,058,164.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,179,765,375.36	1,219,765,375.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	-249,606,824.83	-379,602,942.27
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,978,311,516.30	4,064,431,516.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,057,349,219.74	-1,484,500,277.07
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	283,603,743.82	263,777,089.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-220,885,658.33	-216,066,154.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,248,620.98	33,431,038.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,770,583.50	-17,177,482.06
393	Биет бус хөрөнгө	519,771,600.00	638,721,600.00
39301	Програм хангамж	1,525,000.00	1,525,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,525,000.00	-1,525,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	519,771,600.00	638,721,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,387,308,850.40	5,209,048,245.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	40,000,000.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	40,000,000.00	00.00
413	Өглөг	40,000,000.00	00.00
4136	Бусад өглөг	40,000,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	40,000,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,347,308,850.40	5,209,048,245.97
51	Засгийн газрын хувь оролцоо	4,347,308,850.40	5,209,048,245.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,156,582,358.27	1,156,582,358.27
51101	Өмч: - төрийн	1,156,582,358.27	1,156,582,358.27
512	Хуримтлагдсан үр дүн	2,823,618,596.76	3,685,732,809.13
51210	Өмнөх үеийн үр дүн	2,823,618,596.76	2,823,993,413.56
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	861,739,395.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	367,107,895.37	366,733,078.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,387,308,850.40	5,209,048,245.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,323,471,789.45	5,408,964,146.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,839,473,936.45	2,008,065,146.69
120	Нийтлэг татварын бус орлого	1,839,473,936.45	2,008,065,146.69
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,839,473,936.45	2,008,065,146.69
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,839,473,936.45	2,008,065,146.69
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,483,997,853.00	3,400,899,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,098,046,500.00	2,011,148,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,098,046,500.00	2,011,148,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	385,951,353.00	1,389,750,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	207,970,907.00	1,125,032,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	154,564,566.00	28,390,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,070,880.00	63,043,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,345,000.00	173,285,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,906,337,721.85	4,547,224,751.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,906,337,721.85	4,547,224,751.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,827,160,957.90	4,534,567,877.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,531,231,980.09	1,613,322,367.00
210101	Үндсэн цалин	993,610,725.09	1,047,656,075.00
210102	Нэмэгдэл	480,943,755.00	506,041,292.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,677,500.00	59,625,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,186,111.16	54,501,519.92
210201	Тэтгэврийн даатгал	17,711,953.00	18,472,056.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,083,759.00	2,051,044.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,667,008.00	1,640,835.00
210204	Ажилгүйдлийн даатгал	388,658.00	380,625.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,334,733.16	31,956,959.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,796,924.99	155,523,012.00
210301	Гэрэл, цахилгаан	14,637,753.82	13,288,972.87
210302	Түлш, халаалт	118,561,863.17	138,512,003.13
210303	Цэвэр, бохир ус	3,597,308.00	3,722,036.00
2104	Хангамж, бараа материалын зардал	135,745,134.01	176,561,374.30
210401	Бичиг хэрэг	4,826,650.00	21,506,430.00
210402	Тээвэр, шатахуун	98,509,031.00	128,934,464.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,986,286.31	3,920,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,693,200.00	22,200,080.00
210408	Бараа материал акталсны зардал	21,729,966.70	00.00
2105	Нормативт зардал	213,118,595.08	1,528,365,860.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,464,910.00	1,327,233,875.00
210502	Хоол, хүнс	120,046,331.00	162,890,305.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	36,607,354.08	38,241,680.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,787,415.00	197,531,825.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,320,000.00	154,434,500.00
210604	Урсгал засвар	63,467,415.00	43,097,325.00
2107	Томилолт, зочны зардал	53,908,800.00	18,327,400.00
210702	Дотоод албан томилолт	53,908,800.00	18,327,400.00

**Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	169,381,886.00	207,743,086.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	163,567,270.00	200,794,540.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,130,400.00	1,507,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,207,260.00	1,271,482.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	411,356.00	562,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	791,000.00	354,000.00
210807	Газрын төлбөр	2,034,600.00	2,653,264.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	449,004,111.57	582,691,432.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,559,800.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,526,200.00	3,174,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	441,918,111.57	579,517,432.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,176,763.95	12,656,874.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	3,646,085.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	3,646,085.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,176,763.95	9,010,789.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,176,763.95	9,010,789.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,417,134,067.60	861,739,395.57
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,417,134,067.60	861,739,395.57

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	400,042,860.19	216,528,453.86	863,022,001.47	1,479,593,315.52
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,739,176.06	5,739,176.06
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	400,042,860.19	216,528,453.86	868,761,177.53	1,485,332,491.58
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-5,739,176.06	00.00	-5,739,176.06
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	53,373,696.66	53,373,696.66
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,156,582,358.27	367,107,895.37	2,823,618,596.76	4,347,308,850.40
D01	2021 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,156,582,358.27	367,107,895.37	2,823,618,596.76	4,347,308,850.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	374,816.80	374,816.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,156,582,358.27	367,107,895.37	2,823,993,413.56	4,347,683,667.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-374,816.80	00.00	-374,816.80
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	861,739,395.57	861,739,395.57
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,156,582,358.27	366,733,078.57	3,685,732,809.13	5,209,048,245.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,483,997,853.00	3,444,081,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,483,997,853.00	3,444,081,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,098,046,500.00	2,011,148,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,098,046,500.00	2,011,148,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	385,951,353.00	1,432,932,600.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	207,970,907.00	1,125,032,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	154,564,566.00	28,390,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,070,880.00	63,043,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,345,000.00	216,467,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,483,997,853.00	3,401,826,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,483,997,853.00	3,401,826,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,362,088,989.05	3,389,169,225.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,531,231,980.09	1,613,322,367.00
210101	Үндсэн цалин	993,610,725.09	1,047,656,075.00
210102	Нэмэгдэл	480,943,755.00	506,041,292.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,677,500.00	59,625,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,186,111.16	54,501,519.92
210201	Тэтгэврийн даатгал	17,711,953.00	18,472,056.59
210202	Тэтгэмжийн даатгал	2,083,759.00	2,051,044.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,667,008.00	1,640,835.00
210204	Ажилгүйдлийн даатгал	388,658.00	380,625.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,334,733.16	31,956,959.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,365,912.49	149,097,497.00
210301	Гэрэл, цахилгаан	14,637,753.82	13,288,972.87
210302	Түлш, халаалт	119,130,850.67	132,086,488.13
210303	Цэвэр, бохир ус	3,597,308.00	3,722,036.00
2104	Хангамж, бараа материалын зардал	81,635,186.31	67,854,500.00
210401	Бичиг хэрэг	2,737,600.00	6,183,300.00
210402	Тээвэр, шатахуун	74,411,300.00	53,411,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,986,286.31	3,800,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	4,459,500.00
2105	Нормативт зардал	52,044,330.00	44,705,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	724,500.00	2,110,400.00
210502	Хоол, хүнс	51,136,530.00	42,595,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	183,300.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	149,261,300.00	5,354,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	107,150,900.00	281,600.00
210604	Урсгал засвар	42,110,400.00	5,073,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,636,800.00	1,635,400.00

**Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210702	Дотоод албан томилолт	1,636,800.00	1,635,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	348,595,369.00	1,445,677,946.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	342,769,253.00	1,438,301,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,130,400.00	1,507,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,207,260.00	1,271,482.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	411,356.00	562,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	802,500.00	782,000.00
210807	Газрын төлбөр	2,034,600.00	2,653,264.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,132,000.00	7,019,296.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,617,800.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,514,200.00	7,019,296.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,908,863.95	12,656,874.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,550,000.00	3,646,085.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,550,000.00	3,646,085.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	118,358,863.95	9,010,789.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	118,358,863.95	9,010,789.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	42,255,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	42,255,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	42,255,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	42,255,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	42,255,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-42,255,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,011,148,500.00	2,002,137,710.92	9,010,789.08	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,011,148,500.00	2,002,137,710.92	9,010,789.08	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,006,075,200.00	1,998,491,625.92	7,583,574.08	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,613,421,800.00	1,613,322,367.00	99,433.00	100.0
210101	Үндсэн цалин	951,091,200.00	1,047,656,075.00	-96,564,875.00	110.2
210102	Нэмэгдэл	620,948,600.00	506,041,292.00	114,907,308.00	81.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,382,000.00	59,625,000.00	-18,243,000.00	144.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,835,400.00	54,501,519.92	5,333,880.08	91.1
210201	Тэтгэврийн даатгал	31,817,000.00	18,472,056.59	13,344,943.41	58.1

**Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210202	Тэтгэмжийн даатгал	1,584,700.00	2,051,044.00	-466,344.00	129.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,267,700.00	1,640,835.00	-373,135.00	129.4
210204	Ажилгүйдлийн даатгал	317,000.00	380,625.00	-63,625.00	120.1
210205	Эрүүл мэндийн даатгал	24,849,000.00	31,956,959.33	-7,107,959.33	128.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,305,000.00	149,097,497.00	207,503.00	99.9
210301	Гэрэл, цахилгаан	13,402,900.00	13,288,972.87	113,927.13	99.1
210302	Түлш, халаалт	132,086,800.00	132,086,488.13	311.87	100.0
210303	Цэвэр, бохир ус	3,815,300.00	3,722,036.00	93,264.00	97.6
2104	Хангамж, бараа материалын зардал	67,854,500.00	67,854,500.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	6,183,300.00	6,183,300.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	53,411,300.00	53,411,300.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,800,400.00	3,800,400.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,459,500.00	4,459,500.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	46,134,400.00	44,705,800.00	1,428,600.00	96.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,110,400.00	2,110,400.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	44,024,000.00	42,595,400.00	1,428,600.00	96.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,609,900.00	47,609,900.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,536,600.00	2,536,600.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	45,073,300.00	45,073,300.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,636,800.00	1,635,400.00	1,400.00	99.9
210702	Дотоод албан томилолт	1,636,800.00	1,635,400.00	1,400.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,204,200.00	12,745,346.00	458,854.00	96.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,370,400.00	5,368,800.00	1,600.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,530,400.00	1,507,800.00	22,600.00	98.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,317,800.00	1,271,482.00	46,318.00	96.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	643,100.00	562,000.00	81,100.00	87.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	802,500.00	782,000.00	20,500.00	97.4
210807	Газрын төлбөр	2,940,000.00	2,653,264.00	286,736.00	90.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,073,200.00	7,019,296.00	53,904.00	99.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,073,200.00	7,019,296.00	53,904.00	99.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,073,300.00	3,646,085.00	1,427,215.00	71.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,073,300.00	3,646,085.00	1,427,215.00	71.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,073,300.00	3,646,085.00	1,427,215.00	71.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,011,148,500.00	2,002,137,710.92	9,010,789.08	99.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,011,148,500.00	2,002,137,710.92	9,010,789.08	99.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,011,148,500.00	2,002,137,710.92	9,010,789.08	99.6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,432,932,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,432,932,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,432,932,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,432,932,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,432,932,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1432932600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,432,932,600.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,125,032,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,390,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,043,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	141,467,100.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа бараа материалын үнийг тодорхой тусгах, онцгой комиссоос олгож байгаа зардлын анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавих, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын шийдвэрийг бүрэн байршуулах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 18/02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Онцгой байдлын газар, урьдчилан сэргийлэх тасаг, Гал түймэр унтраах, аврах 16 дугаар анги, Гал түймэр унтраах, аврах 72 дугаар анги, Жаргалант сум дахь Эрэн хайх, аврах салбар, Улсын нөөцийн 127-р салбар, Баянхонгор сум дахь Эрэн хайх, аврах бүлэг, Баянцагаан сум дахь Эрэн хайх, аврах бүлэг, Баянговь сум дахь Эрэн хайх, аврах бүлэг зэрэг бүтэц зохион байгуулалттай, батлагдсан орон тоонд багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

ОБЕГ-ын даргын 2016.12.15-ний өдрийн А/293 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ОБЕГ-ын Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба тус газраас 2021 оны 11 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд санхүүгийн үйл ажиллагаанд албаны шалгалт хийсэн байна.

Хяналт шалгалтын тайлан бичигдээгүй тул дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж аваагүй, аудитад ашиглах баримт материал байхгүй байсан ба дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 2,906,337.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 43,595.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 30,516.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 5,209,048.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 821,739.4 мянган төгрөгөөр буюу 18.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	3	5
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	935,220.3	1,086,268.5	151,048.2
Авлага	73,182.1	30,000.0	(43,182.1)
Бараа материал	862,038.2	1,056,268.5	194,230.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,452,088.6	4,122,779.8	670,691.2
Үндсэн хөрөнгө	4,995,225.9	6,221,651.6	1,226,425.8
Хуримтлагдсан элэгдэл	(1,543,137.3)	(2,098,871.9)	(555,734.6)
Нийт хөрөнгө	4,387,308.9	5,209,048.2	821,739.4
Өр төлбөр	40,000.0	-	(40,000.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,347,308.9	5,209,048.2	861,739.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,387,308.9	5,209,048.2	821,739.4

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 2 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд 73,182.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэйгээс тайлант онд өмнөх оны нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл төвлөрүүлж, авлагаар бүртгэсэн 43,182.1 мянган төгрөгийн авлага барагдсан байна. Харин 2018 онд үүссэн суудлын автомашинтай холбоотой "Сод ноёд" ХХК-аас авах 30,000.0 мянган төгрөгийн авлага нь барагдаагүй үлдэгдлээр байгаа бөгөөд тус асуудлыг Авлигатай тэмцэх газар шалгаж байгаа гэсэн тайлбарыг шалгадагч байгууллагаас ирүүлсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,056,268.5 мянган төгрөг болж өмнөх оноос 194,230.3 мянган төгрөгөөр өссөн ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 129,520.7 мянга, аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 1,203,717.1 мянга, нийт 1,333,237.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 617,973.3 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч ОБЕГ-н харьяа ар талын 115 дугаар ангиас 182,138.1 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 1,939,118.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Өмнөх оны 4,995,225.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж Баянговь, Баянцагаан сумын эрэн хайх аврах бүлгийн авто гражийн барилгад ОБЕГ-аас тус бүр 20.0 сая төгрөгийг баталж, хөрөнгөд орлогоор авсан, төсвийн хөрөнгөөр 2,255.0 мянган төгрөгийн үнэ бүхий 4 ширхэг принтер худалдан авсан байна.

Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газраас 8,000.0 мянган төгрөгийн УАЗ-469 маркийн 2 машин, ОБЕГ-аас 1,035,120.0 мянган төгрөгийн Рено загварын галын үндсэн албаны автомашиныг шилжүүлэн авч, Засгийн газрын 2021 оны 297 дугаар тогтоолоор 43.0 сая төгрөг фургонмашиныг олгожээ. Тайлант онд аймгийн Засаг даргын 2020.10.20-ний өдрийн А/673 дугаар захирамжаар 4758м² талбай бүхий газар олгосныг бүртгэлд тусгажээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021.12.30-ний өдрийн 725 дугаар тогтоолоор нийт 23,782.8 мянган төгрөгийн 13 нэр төрлийн үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсныг хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх онд аймгийн Засаг даргын шийдвэрийн дагуу Баянхонгор аймгийн зорилтот бүлгийн иргэдэд олгосон хүнсний материалын үнийн өглөг 40,000.0 мянган төгрөг бүртгэлтэй байсныг тайлант онд онцгой комиссын хандив тусламжаас шилжүүлж, өглөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 861,739.4 мянган төгрөгөөр нэмэгдэж 5,209,048.2 мянган төгрөг болсон байна.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын улсын төсвөөс өмнөх онд 2,098,046.5 мянган төгрөг авсан бол тайлант онд Баянцагаан, Баянговь сум дахь Эрэн хайх, аврах бүлгүүдэд төсвийн хөрөнгөөр авто гараж баригдсан, гэрэл цахилгааны зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, урьдчилан сэргийлэх зардлууд өмнөх оноос нэмэгдсэнтэй холбоотой тайлант оны санхүүжилт өмнөх оноос 86,898.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,011,148.5 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын даргын 2020.04.30-ний өдрийн 18/137 дугаар албан бичгээр 2021 оны төсвийн төлөвлөлтийг 2,813,772.1 мянган төгрөгөөр төлөвлөж, ОБЕГ-т хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70708 хөтөлбөрийн 80101, 80802, 82310 гэсэн арга хэмжээг санхүүжүүлэх төсвийн хуваарийг цаасаар ирүүлээгүй нь орон тоо нууцлалын зэрэгт шилжсэнтэй холбоотой ба Сангийн яамны э-хуулганаас төсвийг хянаж ирсэн байна.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар тайлант онд улсын төсвөөс авахаар батлагдсан 2,011,148.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, 2,002,137.7 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 9,010.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 1,432,932.6 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан бөгөөд нийт орлогын 78.5% буюу 1,125,032.5 мянган төгрөг нь иргэн, аж ахуйн нэгжүүдээс ковид 19 цар тахалтай холбоотой өгсөн хандив ба тус хандивыг аймгийн Засаг даргын захирамжаар зарцуулсан байна.

Д/д	Орлогын төрөл	Авсан санхүүжилт
1	Иргэн, аж ахуйн нэгжүүдээс олгосон хандив	1,125,032,500
2	Сангийн яамнаас олгосон өмнөх оны татаас санхүүжилтийн авлага	43,182,100.00
3	ОБЕГ-аас олгосон гамшгийн томилолт	57,843,000.00
4	ОБЕГ-аас олгосон нөөцийн бараа сэлгэлтийн зардал	3,000,000.00
5	ОБЕГ-аас олгосон ахмадын сангийн санхүүжилт	2,200,000.00
6	Баянхонгор аймгийн Нисэх буудлаас төлбөр	2,550,000.00
7	Аймгийн Засаг даргын захирамжаар Сум дундын Ойн ангиас шилжүүлсэн	95,000,000
8	Аймгийн Засаг даргын А/75, А/611 дүгээр захирамжаар олгосон санхүүжилт	80,390,000
9	Төсөвт байгууллага, эмийн сангуудаас төлсөн эмчилгээний багцын үнэ	2,200,000
10	Цахим тендерийн материалын үнэ	35,000
11	Буцсан гүйлгээ	21,500,000
ДҮН		1,432,932,600

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн онцгой комиссын хөрөнгийн зарцуулалтыг тус байгууллага хариуцдаг ба тайлант онд илэрсэн дараах алдаануудыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд оруулахаар шийдвэрлэв. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын 2021.08.06-ний өдрийн А/490 дүгээр захирамжаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт 32613100 төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн зориулалттай угаалгын машин авахаар "Ай мед техноложис" ХХК-тай гэрээг 2021.06.30-ны өдөр байгуулжээ. Тус гэрээний 3.1-т тоног төхөөрөмжийг 2021.07.30-ний дотор багтаан хүлээлгэн өгөхөөр заасан ба 2021.07.25-ний өдөр дэд хурандаа Э.Батбаяр хүлээн авсан тухай актыг үйлдэж, 2021.08.05-ний өдөр мөнгийг шилжүүлсэн байна. Аудитаар аймгийн Нэгдсэн эмнэлгээс хөрөнгийн жагсаалтыг авч тулгалт хийхэд тус тоног төхөөрөмжийг хил гааль хаагдсаны улмаас хүлээн аваагүй, 2022 оны 01 дүгээр сард хүлээн авсан гэсэн тайлбарыг өгсөн. Аудитаар хөрөнгийг тулган шалгахад аймгийн Нэгдсэн эмнэлгийн гаражид байсан, одоогоор хөрөнгийг суурилуулаагүйгээс ашиглаж эхлээгүй байгаа тул тус хөрөнгийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн хөрөнгөд орлогод авч, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж, 2022.06.10-ний дотор ашиглах албан шаардлагыг өглөө.
2. Байгууллага, эмийн сангуудад дархлаа сэргээх бүтээгдэхүүнийг аймгийн ЗДТГ-аар дамжуулан эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон ба тайлант онд 2,200.0 мянган

төгрөгийн орлого орж, бусад байгууллагуудад олгосон 9,040.0 мянган төгрөгийг төлүүлээгүй зөрчилтэй тул байгууллагуудаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Иймд цаашид байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан аймгийн Засаг даргын захирамжийн дагуу олгосон зардлын зарцуулалтад тавих хяналтыг аймгийн Онцгой байдлын газрын удирдлага, нягтлан бодогч нарын зүгээс сайжруулах нь зүйтэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2021 онд 4 зорилтын хүрээнд 57 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95 хувьтай гаргаж, Онцгой байдлын Ерөнхий газарт хүргүүлсэн боловч дүгнээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь 2021 онд нийт 3,813,914.4 мянган төгрөгийн 78 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 262.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 148 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 2021 оны 01 дүгээр сард байгууллагын даргын Б/01, Б/02 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/75 дугаар захирамжийг хугацаа хоцроож мэдээлснээс 1 мэдээлэл хугацаа хоцроосон зөрчилтэй байна.

Хүснэгт 2. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон
1	Бүтэн жил	9	9	9	0
2	Хагас жил	4	4	4	0
3	Улирал бүр	1	4	4	0
4	Сар бүр	3	36	36	0
5	Тухай бүр	8	96	95	1
	Нийт	25	149	148	1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын шилэн данс

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, ТБОНӨХБАҮХАТХ болон Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан нь холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд гүйцэтгэж, 1 зөвлөмж өгсөн боловч бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,631.0 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 2 зөрчилд үнийн дүнгүй 2 албан шаардлага өгч, 4,631.0 мянган төгрөгийн зөрчилд байгууллагын удирдлагад 3 зөвлөмжийг хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Баянхонгор аймгийн Засаг даргын 2021.09.21-ний өдрийн А/587 дугаар захирамжаар "Команд штаб" дадлага сургуулилтыг зохион байгуулж, 5 нэр төрлийн 23,250.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 10,525.0 мянган төгрөгийн 2 төрлийн 5 ширхэг майхныг орон нутгийн хөрөнгөд бүртгүүлээгүй, байгууллагын хөрөнгөд бүртгэсэн байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна...", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 дахь "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын хөрөнгөөс хасан, аймгийн ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэмж залруулав.

4.2 Албан шаардлага

1. Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар "Тус байгууллагын эзэмшлийн талбайд "Би эйч энд ди" ХХК-ийн эзэмшлийн уурын зуухны барилга барьж, халаалтын үйл ажиллагаа явуулж байгаа зөрчлийг арилгах" зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Төрийн өөрийн өмчид энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж болох төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө хамаарна" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Байгууллагын төсвийн хөрөнгөөр хашаа баригдаагүй байгаа ба аудитын явцад төсвийн захирагчаас тухайн онд хийгдсэн засварын ажлын талаарх мэдээллийг албан

бичгээр гаргуулан авахад хандиваар хашааг шинэчлэн хийсэн байгаа боловч тайлант онд хөрөнгөд нэмж бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "Нягтлан бодох бүртгэлд... бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь "Талст бадмаараг" ХХК, "Баян баялаг өргөө" ХХК-тай байгуулсан хүнсний материал худалдан авах гэрээнд хүнсний материалын үнийг тодорхой тусгаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулахдаа худалдан авах бараа бүтээгдэхүүний үнийг тодорхой тусгаж, гэрээний үнэнд хяналт тавьж ажиллах.

2. Зардлын холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Ковид цар тахалтай холбоотой иргэн, аж ахуйн нэгжээс өгсөн хандивыг Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан. Анхан шатны баримтыг тулган шалгахад аймгийн Онцгой комисст 2021.05.27-нд өгсөн 1,712.0 мянга, 2021.08.04-нд хүлээлгэн өгсөн 1,596.9 мянган төгрөгийн шатахуун, 2021.05.27-нд хүлээлгэн өгсөн 1,060.0 мянган төгрөгийн дархлаа дэмжих 20 багцын анхан шатны баримт байхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Аймгийн Засаг даргын захирамжаар олгож байгаа анхан шатны баримтын бүрдлийг сайжруулж, Нягтлан бодох бүртгэлийг тухай хуулийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын 2021.01.05-ний өдрийн 278.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулах тухай А/17, А/18 дугаар тушаалыг байршуулаагүй, шилэн дансны самбарт мэдээллийг шинэчлээгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг тухай бүр байршуулж, байгууллагын мэдээллийн самбарт тавигдсан мэдээллийг шинэчилж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар	6	38406.0	1	33,775.0	0	0	2	0.0	3	4631.0
---oOo---											